Бараа материалын дансны үлдэгдэл Ерөнхий боловсролын сургууль 640.7, Эрүүл мэндийн төв 13280.5, ЗДТГазар 6893.9 мянган төгрөгөөр тус тус өссөн нь Ерөнхий боловсролын сургуулийн тусгай зориулалтын бараа материал, ЗДТГ-ын аж ахуйн материал, 32 тн нүүрсний үлдэгдэл, Эрүүл мэндийн төв Ковид-19 цар тахлын бэлэн байдлын шаардлагатай бараа материал нөөцөлсөнтэй холбоотой байна. Тайланд онд 9307.6 мянган төгрөгөөр хандив, үнэ төлбөргүйгээр бараа материал нэмэгдэж 259043.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5780911.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7049688.7 мянган төгрөг болж, 1268777.1 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт № 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	2723146.3	3877101.6	1153955.3
Тээврийн хэсэгсэл	163029.2	116549.2	-46480
Машин тоног төхөөрөмж	355011.5	389622.6	34611.1
Тавилга эд хогшил	170911	212484.6	41573.6
Түүх соёлын дурсгалт зүйл	2003.8	2003.8	0
Зам гүүр барилга байгууламж	147,691.9	199275.3	51583.4
Номын фонд	40483.7	42840.9	2357.2
Бусад үндсэн хөрөнгө	2102649.3	2135499.3	32850
Програм хангамж	6351.5	4678.0	-1673.5
Бусад биет бус хөрөнгө	69633.4	69633.4	0
Дүн	5,780,911.60	7049688.7	1268777.1

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвөөс 98970.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, үнэ төлбөргүй хандиваар, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1238808.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5331.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 17205.3 мянган төгрөг болж, 11873.6 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн			
Ажилчидтай холбогдсон өглөг	2319.1	496.3	(1822.8)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	168.7	258.7	90.0

Татаас санхүүжилтийн өглөг		16738.8	16738.8
Байгууллагад төлөх өглөг	2647.2		(2647.2)
Хувь хүмүүст төлөх өглөг	196.7	29.8	(166.9)
Нийт дүн	5331.7	17205.3	11873.6

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаа өглөгүүд 2021 оны тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5126669.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6242348.8 мянган төгрөг болж, 1115679.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1507216.0	1507216.0	-
Хуримтлагдсан үр дүн	1930332.8	3046012.5	1115679.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1689120.2	1689120.2	-
Дүн	5126669.1	6242348.8	1115679.7

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй, хуримтлагдсан үр дүн 3046012.5 мянган төгрөг болж 1115679.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 1116213.3 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд СХС-ийн алданги, хүүг өмнөх онд зөрүүтэй тооцсоноос шалтгаалан бүртгэгдсэн 557.1 мянган төгрөгийн алдааны залруулга байна.

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар татварын бус орлого 994982.1, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 982616.6, тусгай шилжүүлгийн санхүүжилт 236856.2, орон нутгаас олгох санхүүжилт 128014.7, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 97809.4, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 7096.9, ЭМДСангаас 16355.2 мянган төгрөгөөр өссөн, татварын орлого 41687.9, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих орлого 28228.6 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2977626.4	4492878.5	1515252.0
Татварын орлого	108478.6	66790.6	(41687.9)
Татварын бус орлого	263709.2	1258691.4	994982.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	251495.6	1234112.3	982616.6
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1507491.6	1744347.8	236856.2
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	482385.0	610399.7	128014.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	68878.9	172932.8	104053.9
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	95011.4	66782.8	(28228.6)
Урьд оны үлдэгдлээс санхүүжих			
Орон нутгийн төсөвт байгууллага төвлөрүүлэх шилжүүлэг		7096.9	7096.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	432090.6	529900.0	97809.4

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19581.0	35936.2	16355.2
---	---------	---------	---------

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх оны аудитаар өгөгдсөн сум хөгжүүлэх сангаас зээл аваад зээлийн хугацаа хэтэрсэн зээлдэгч нартай холбоотой 70 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг хуулийн байгууллагад шилжүүлж зээлийн эргэн төлөлтийг сайжруулаагүй тайланд онд зээл, зээлийн хүүд төлүүлэх 32939.1 мянган төгрөгөөс 5280.2 мянган төгрөгийн зээл зээлийн хүү эргэн төлөгдсөн байна.
- Малжуулах төслөөр 2014-2016 онд олгосон 8000.0 мянган төгрөгийн 5 иргэнтэй холбоотой авлага барагдуулах арга хэмжээ аваагүй.

3.5.11 Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 534824.3 мянган төгрөгөөр буюу 18.8 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, урсгал шилжүүлэг, хөрөнгийн зардлууд тус тус өссөн, хангамж бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, нормативт зардал, томилот зочны зардлууд буурсан байна.

Хүснэгт № 9 . Зарлагын гүйцэтгэл

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
	2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2840840.8	3375665.1	534824.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1407185.9	1689551.1	282365.1
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	186663.6	216243.6	29580.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89669.3	96824.7	7155.4
2104	Хангамж, бараа материалын зардал	142832.0	127931.9	(1490060)
2105	Нормативт зардал	145562.5	95611.4	(49951.0)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27234.6	9378.9	(17855.7)
2107	Томилот, зочны зардал	9128.7	3308.0	(5820.7)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	60808.3	73392.9	12584.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266279.5	277076.9	10797.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	503179.6	786345.2	283165.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2296.4	0	2296.4

Аудитын илрүүлэлт:

- ОНХС-ын төсөв төлөвлөгөөнд иргэдийн санал асуулгаар эрэмбэлэгдээгүй Мөнгөлөг шагшуурга, цас мөсний баярын хөтөлбөр 531.6, Цаг уур өртөө болон айл өрхүүдийг нэгдсэн халаалтын шугамд холбох 4200.0, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил 1000.0, Корона вирус өвчний урьдчилан сэргийлэх багж хэрэгсэл, ариутгал бодис худалдан авах зардал 2869.7 нийт 8601.3 мянган төгрөгийг хөтөлбөр арга хэмжээнд төлөвлөж зарцуулсан.
- Батлагдсан Олон үндэстэн ястны өв соёл хөтөлбөр, Хогны менежмент, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Тайван амгалан Ховдчууд хөтөлбөрүүдээс удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлууд санхүүжүүлсэн байна. Тухайлбал: Шатахуунд 1242.3, өргөмжлөл медаль 1412.5, маскны үнэ 300.0, ариутгалд 355.0, Серикбергений дансанд 354.6, насосны үнэ 280.0, худгийн засварт 478.4, нийт 4422.8 мянган төгрөг

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Ховд сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 10/3 дугаар тогтоолд Ховд сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 41368.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 66790.7 мянган төгрөгийн татварын орлого, татварын бус орлого 17858.9 мянган төгрөг, бүгд 84649.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 204.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10. Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	0	0	
Нийт орлого ба тусламжийн дйн	41368.5	66790.7	(25422.2)
Татварын орлого	41368.5	66790.7	(25422.2)
Орлогын албан татвар	11290.0	36511.2	(25221.2)
Хувь хүний орлогын албан татвар	11290.0	36511.2	(25221.2)
Үйл ажиллагааны орлого	790.0	8641.0	(7851.0)
Шууд бус орлого	10500.0	27870.2	(17370.2)
Хөрөнгийн албан татвар	24416.0	25472.8	(1056.8)
Бууны албан татвар	2376.0	660.0	1716.0
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	22040.0	24812.8	(2772.8)
Бусад татвар, телбер, хураамж	5662.5	4806.7	755.8
Бусад нийтлэг телбер, хураамж	3360.0	4315.6	(955.6)
Улсын тэмдэгтийн хураамж	2450.0	2869.3	(419.3)
Тигээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	200.0	987.3	(787.3)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	710.0	459.0	251
Газрын телбер		164.4	(164.4)
Байгалийн нөөц ашигласны телбер	2302.5	326.7	1975.8
Ан амьтны нөөц ашигласны телбер			
Ус, рашааны нөөц ашигласны телбер	802.5	0	802.5
Байгалийн ургамлын нөөц ашигласны телбер	1500.0	326.7	(1173.3)

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2336208.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2336208.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 22834.8 мянган төгрөгөөр нэмж 25171103.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2517103.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2374415,3 мянган төгрөгийг урсгал зардалд, 91188,3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 51500.0 мянган төгрөг тус тус зарцуулахаар батлагджээ.

Тайлант онд батлагдсан төсөв 2517103.6 мянган төгрөгийн, 1741780.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжихээр, 588292.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжихээр, 35953.4 мянган төгрөгийг ЭМД-ын сангаас санхүүжихээр, 4605.0 төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр ОНХС-ийн хөрөнгөөр 94972.8 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 51500.0 мянган төгрөг тус тус төлөвлөжээ.

Батлагдсан төсөв нь гүйцэтгэлээр тусгай шилжүүлгээс 1633034.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 575112.8 мянган төгрөг, ЭМД-ын сангаас 35936.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2551.0 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр 94972.8 мянган төгрөг, СХСангийн зээлийн эргэн төлөлтөөс 5280.0 мянган төгрөг нийт 2346887.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн зардлын хэмнэлтээс 7096.0 мянган төгрөг, нэмэлт дансны орлого болох 16709.0 мянган төгрөг бүгд 23805.0 мянган төгрөгийг сумын ерөнхий дансанд төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 2363.5 мянган төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 1741.5 мянган төгрөгөөр тасарсан нь Соёлын төвийн өөрийн орлого тасарсантай холбоотой байна. Мөн сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 46338.0 мянган төгрөгийн орлого бүрдээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын 17 төсөл, арга хэмжээнд 81462.8 мянган төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 76064.1 мянган төгрөгийн ажил хийгдэж “Корона вирус Цар тахал” өвчний улмаас 3 ажил дутуу хийгдэж одоо дансанд 5398.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	Тайлбар
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт		
1	ЗДТГ	392,368.6	2,605.0	394,973.6	383,908.5	2,363.5	386,272.0	(8,701.6)	Орон нутагт төвлөрүүлсэн
2	ИТХ	56,896.6	-	56,896.6	56,325.8	-	56,325.8	570.8	Орон нутагт төвлөрүүлсэн
3	Сум хөгжүүлэх сан	51,500.0	-	51,500.0	5,280.2	-	5,280.2	(46,219.8)	СХС зээлийн эргэн төлөлт төлөвлөгдсөн хэмжээнд бүрдээгүй
4	ОНХС	81,462.8	-	81,462.8	76,064.1	-	76,064.1	5,398.7	Төлөвлөгдсөн төсөл хөтөлбөрийн зардал санхүүжүүлээгүйтэй холбоотой мөнгө үлдсэн
ОНБ-дын дүн		582,228.0	2,605.0	584,833.0	521,578.6	2,363.5	523,942.1	(48,951.9)	
5	ЕБСургууль	1,143,751.3	500.0	1,144,251.3	1,077,440.9	187.5	1,077,628.4	66,622.9	Төвлөрүүлэв
6	Хүүхдийн цэцэрлэг	288,308.9	-	288,308.9	247,601.9	-	247,601.9	40,707.0	Төвлөрүүлэв
7	Эрүүл мэндийн төв	417,239.5	-	417,239.5	415,387.6	-	415,387.6	(1,851.9)	ЭМДС-аас дутуу санхүүжилт авсан
8	Соёлын төв	80,954.7	1,500.0	82,454.7	76,966.0	-	76,966.0	5,488.7	Өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан,

							хэмнэсэн зардлыг төвлөрүүлсэн
ТЗШ дүн	1,930,254.4	2,000.0	1,932,254.4	1,817,396.4	187.5	1,817,583.9	110,966.7
Нийт дүн	2,512,482.4	4,605.0	2,517,087.4	2,338,975.0	2,551.0	2,341,526.0	62,014.8

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төсөл хөтөлбөр хөрөнгө оруулалтын ажилд сумд эрх шилжүүлснээр шинээр Баянбулаг багт өндөр хүчдэлийн шугам татагдсан мөн гүн өрөмдмөлийн худаг гаргасан, тавилга, тоног төхөөрөмж худалдаж авсан. Сумын 2019 оны давсан орлогыг хуваарилж, ОНХСангийн хөрөнгөөр ТЗШ-ийн байгууллагуудад их засвар, тоног төхөөрөмж худалдан авахаар ИТХурлын тогтоолоор хөрөнгө баталсан, Статистикийн судалгааны зардал, Онцгой байдлаас томилолтын зардал, нэмэлт орлогын дансанд 172932.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 16709.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №12. Нэмэлт данс /мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нэмэлт төсөв			Тайлбар
		НДШ листийн орлого	Бусад орлого	Нийт	
1	ЗДТГ	-	121,890.1	121,890.1	Аймгийн ОНХС хөрөнгө оруулалт 100941.1 мянган төгрөгийн их засвар, тоног төхөөрөмж авсан, цахилгааны өндөр хүчдэлийн шугам, худаг шинээр баригдсан, хүн амын тооллогын зардал 4906.4 мянган төгрөг, 16043.0 төгрөгийг төвлөрүүлсэн
2	ИТХ			-	
3	ЕБСургууль		35,560.0	35,560.0	аймаг сумын ОНХС хөрөнгө оруулалтаар тавилга их засвар хийгдсэн 35560.0 төг
4	Хүүхдийн цэцэрлэг	-	4,484.4	4,484.4	ОНХС-аас 4050.0 мянган төгрөг, тавилга тоног төхөөрөмж 434.4 мянган төгрөг хоолны үнэ
5	ЭМТ		9,998.3	9,998.3	ОНХС-аар 5000.0, ЭМГазраас-өөс 4998.3
6	Соёлын төв		1,000.0	1,000.0	ОНХС-аас 1000.0 мянган төгрөг засвар
Нийт дүн		-	172,932.8	172,932.8	

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 97 мэдээллийг хугацаанд нь, 40 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг огт мэдээлээгүй, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй, 120000.7 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд илэрснийг 1 алдааг залруулж 119000.8 мянган төгрөгт 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 66.6 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 13. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	119000.8	2	49000.8	1	70000.0	66.6%
Нийт	3	119000.8	2	49000.8	1	70000.0	66.6%

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №14. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			Аудитын дүгнэлт	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Гэрээгээр хийлгэсэн	Зөрчилгүй	хязгаарлалттай
1	ЗДТГ	1			1	
2	ИТХ		1			
3	Төсвийн шууд захирагч	Сургууль	1		1	
4		Цэцэрлэг	1		1	
5		Соёлын төв	1		1	1
6		ЭМТөв	1			1
7	ОНТС	СХС		1		
8		ОНХС		1		
Дүн		5	3	1	5	0

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-5, дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 41680.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4715.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 36483.0 мянган төгрөгийн 4 алдааг арилгах 2 албан шаардлага, 482.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

- Сумын ЗДТГ-ын нэмэлт дансанд төвлөрсөн хүү торгуулийн орлогоос 515.6 мянган төгрөгийг хүү торгуулийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн “23.3.Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг,эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, ...орлогоос бүрдэнэ”, “23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, гэсэн заалтуудыг зөрчсөн, аудитын “тохиолдсон байх”, “үнэлгээ”, “толилуулга ба тодруулга”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох.

- ОНХС-ийн журмыг зөрчиж цаг уурын өртөөг нэгдсэн халаалтын шугамд холбох, засварлах 4200.0 мянган төгрөгийг Вива зоне ХХК-д шилжүүлсэн ба суманд нэгдсэн халаалт ороогүй тухайн ажил нь хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1. “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 6.1 “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.5 “Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, аудитын “тохиолдсон байх”, “үнэлгээ”, “толилуулга ба тодруулга”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох.

- Тайлант онд ОНХС-аас 2020 онд иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 4 ажил, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн, ОНХС-ын хөтөлбөрүүдээс удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлууд санхүүжүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 60.3.1. “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.3.6-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд хөрөнгө зарцуулахыг хориглоно”, 60.4. “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам 4.2. “ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно”, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 6.3. “Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд хариуцан барагдуулна” заалтуудтай тус тус нийцээгүй, аудитын “тохиолдсон байх”, “үнэлгээ”, “толилуулга ба тодруулга”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

- СХС-ын хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг хуулийн байгууллагад шилжүүлж зээлийн эргэн төлөлтийг сайжруулаагүй, Малжуулах төслөөр 2014-2016 онд олгосон 8000.0 мянган төгрөгийн 5 иргэнтэй холбоотой авлага барагдуулах арга хэмжээ аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 6.3. “Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд хариуцан барагдуулна” заалтуудтай тус тус нийцээгүй, аудитын “тохиолдсон байх”, “үнэлгээ”, “толилуулга ба тодруулга”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Төвлөрүүлсэн захирагчид 482.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Ховд сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 81471.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 14549.0 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 58922.6 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 4715.6 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд төлбөрийн акт, 36483.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд 2 албан шаардлага, 17724.0 мянган төгрөгийн 11 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 15. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	6	11513.1	-	-	6	11513.1
2		ИТХ	-	-	-	-	-	-
3		Сургууль	6	17026.2	4	11724.0	2	5302.2
4		Цэцэрлэг	3	3767.3	1	2825.0	2	942.3
5		Соёлын төв	1	-	-	-	1	-
6	ОНТС	СХС	2	27658.9	-	-	2	27658.9
7		ОНХС	3	13506.1	-	-	3	13506.1
		Дүн	21	73471.6	5	14549.0	16	58922.6

№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил	Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн		
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	6	11513.1	1	515.6	-	-	5	10997.5
2		ИТХ	0	-	-	-	-	-	-	-
3		Сургууль	2	5302.2	-	-	-	-	2	5302.2
4		Цэцэрлэг	2	942.3	-	-	-	-	2	942.3
5		Соёлын төв	1	-	-	-	-	-	1	-
6	ОНТС	СХС	2	27658.9	-	-	2	27658.9	-	-
7		ОНХС	3	13506.1	1	4200.0	1	8824.1	1	482.0
		Дүн	16	58922.6	2	4715.6	3	36483.0	11	17724.0

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар ОНХС-ийн төлөвлөлтийн талаар авч үзэхээс өөр анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: ОНХС-ын олон үндэстэн ястны өв соёл хөтөлбөрөөс н.Серикбергений данс руу шилжүүлэх 1820.0 мянган төгрөгөөс ашиг суутгасан боловч сумын татварын данс руу шилжүүлээгүй, Баруун салаа багийн хашаа барих ажлын санхүүжилтийг н.Хусманы данс руу шилжүүлэхдээ ашиг суутгалгүй 3000.0 мянган төгрөг шилжүүлсэн зөрчил илэрлээ.
- 1.2. Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага, хувь хүн татвараас зайлсхийх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж,

худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах. Хувь хүнээс суутгасан ашгийн татварыг татварын орлогын дансанд төвлөрүүлж хэвших.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

2.1 . Төрийн сангийн гүйлгээтэй холбоотой асуудал

2.1.1. Илрүүлэлт: Сумын хэмжээнд гүйлгээ хийж байгаа төсөвт байгууллагууд, ОНХС, СХС-гийн дансны хуулгаар буцсан гүйлгээ их гарч байгаа зөрчил илэрлээ.

2.1.2. Эрсдэл: Төрийн сангийн гүйлгээ үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж. Байгууллагуудын дансны гүйлгээнд буцсан гүйлгээнүүд их гарч байгаад анхаарч, дотоод хяналт, гүйлгээ бүрт тавих төрийн сангийн хяналтыг сайжруулах.

2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Ховд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
2020			ХОА-2021/04/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ховд сумын Засаг дарга		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	ОНХС-аас 2020 онд иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 4 ажил, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн.	4401.3	Албан шаардлага	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Я.Өмирхан, Д.Жолды, К.Жанбота
2	ОНХС-ын хөтөлбөрүүдээс удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлууд санхүүжүүлсэн байна.	4422.8	Албан шаардлага	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Я.Өмирхан, Д.Жолды, К.Жанбота
3	СХС-ын хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг хуулийн байгууллагад шилжүүлж зээлийн эргэн төлөлтийг сайжруулаагүй	27658.9	Албан шаардлага	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Я.Өмирхан, Д.Жолды, К.Жанбота

4	Малжуулах төслөөр 2014-2016 онд олгосон 8000.0 мянган төгрөгийн 5 иргэнтэй холбоотой авлага барагдуулах арга хэмжээ аваагүй.	0	Албан шаардлага	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Я.Өмирхан, Д.Жолды, К.Жанбота
5	ОНХС-ийн журмыг зөрчиж цаг уурын өртөөг нэгдсэн халаалтын шугамд холбох, засварлах гэж Вива зоне ХХК-д шилжүүлсэн ба суманд нэгдсэн халаалт ороогүй тухайн ажил нь хийгдээгүй.	4200.0	Төлбөрийн акт	Засаг дарга, нягтлан бодогч	Я.Өмирхан, Д.Жолды, К.Жанбота
6	Сумын ЗДТГ-ын нэмэлт дансанд төвлөрсөн хүү торгуулийн орлогоос 515600 төгрөгийг хүү торгуулийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан.	515.6	Төлбөрийн акт	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Х.Өнерхан, Т.Ернур
7	ОНХС-аас хувь хүмүүст олгох санхүүжилтээс ашиг суутгаагүй 300.0, суутгасан боловч татварын дансруу төвлөрүүлээгүй 182.0 мянган төгрөг зөрчил илэрлээ.	482.0	Зөвлөмж	Засаг дарга, нягтлан бодогч	Я.Өмирхан, К.Жанбота
8	Төрийн сангийн гүйлгээнүүдэд буцсан гүйлгээ их байна.	0	Зөвлөмж	Санхүүгийн албаны дарга, Төрийн сангийн мэргэжилтэн	Д.Жолды, Х.Володя
	Дүн	41680.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 22/А.2170425

Ховд

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар сумын ЗДТГ-ын нэмэлт дансанд төвлөрсөн хүү торгуулийн орлогоос 515600 төгрөгийг хүү торгуулийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн "23.3.Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг,эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого,орлогоос бүрдэнэ", "23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "20.2.5.-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Дээр дурдсан 515600 /таван зуун арван таван мянга зургаан/ төгрөгийг ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нараас суутган Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2021 оны 5 дугаар сарын 30-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг сумын ЗДТГ-ын дарга Х.Өнөрхан, нягтлан бодогч Т.Ернур нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

А.ЦЭЦЭГСҮРЭН
Ц.АЗЗАЯА

¹ Монгол улс, Ховд аймаг, Цамбагараа баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545

021050116



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 83/А.2170425

Ховд

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 4200000 төгрөгийг ОНХС-ийн журмыг зөрчиж цаг уурын өртөөг нэгдсэн халаалтын шугамд холбох, засварлах гэж Вива зоне ХХК-д шилжүүлсэн ба суманд нэгдсэн халаалт ороогүй тухайн ажил нь хийгдээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1. "орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ", 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.5 "Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

3. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн данснаас олгосон 4200000 /Дөрвөн сая хоёр зуун мянган/ төгрөгийг "Вива зоне" ХХК-наас гаргуулж Төрийн сан банкин дахь Ховд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 100101352400 тоот дансанд 2021 оны 04 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
4. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 01-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэхийг Ховд сумын Засаг дарга Я.Өмирхан, Санхүүгийн албаны дарга Д.Жолды, Орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогч К.Жанбота нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Ц.АЗЗАЯА

² Монгол улс, Ховд аймаг, Цамбагарае баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545

021050113



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 66/А.2190425

Ховд

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн сум хөгжүүлэх сангаас зээл аваад зээлийн хугацаа хэтэрсэн зээлдэгч нартай холбоотой 70 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг хуулийн байгууллагад шилжүүлж зээлийн эргэн төлөлтийг сайжруулаагүй тайланд онд зээл, зээлийн хүүд төлүүлэх 32939.1 мянган төгрөгөөс 5280.2 мянган төгрөгийн зээл зээлийн хүү эргэн төлөгдсөн байна.
2. Малжуулах төслөөр 2014-2016 онд олгосон 8000.0 мянган төгрөгийн 5 иргэнтэй холбоотой авлага барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 6.3. "Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд хариуцан барагдуулна" заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. 2010-2019 оны хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг хуулийн байгууллагад шилжүүлж зээлийн эргэн төлөлтийг сайжруулан ажиллах.
2. Малжуулах төслөөс 2014-2016 онд зээл авсан нэр бүхий 5 иргэнтэй холбоотой асуудлыг холбогдох арга хэмжээ авч 8000.0 төгрөгийг эргэлтэд оруулах.
3. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 30-ны дотор Ховд аймгийн төрийн аудитын газарт⁴ ирүүлэхийг Ховд сумын Засаг дарга Я.Өмирхан, Санхүүгийн албаны дарга Д.Жолды, нягтлан бодогч К.Жанбота нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН
АУДИТОР ЦАЗЗАЯА

⁴ Монгол улс, Ховд аймаг, Цамбагаараг баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545

021040160



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 65/А 2170425

Ховд

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ОНХС-ын төсөв төлөвлөгөөнд иргэдийн санал асуулгаар эрэмбэлэгдээгүй Мөнгөлөг шагшурга, цас мөсний баярын хөтөлбөр 531.6, Цаг уур ертөө болон айл өрхүүдийг нэгдсэн халаалтын шугамд холбох 4200.0, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил 1000.0, Короно вирус өвчний урьдчилан сэргийлэх багж хэрэгсэл, ариутгал бодис худалдан авах зардал 2869.7 нийт 8601.3 мянган төгрөгийг хөтөлбөр арга хэмжээнд төлөвлөж зарцуулсан.
2. Батлагдсан Олон үндэстэн ястны өв соёл хөтөлбөр, Хогны менежмент, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Тайван амгалан Ховдчууд хөтөлбөрүүдээс удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлууд санхүүжүүлсэн байна. Тухайлбал: Шатахуунд 1242.3, өргөмжлөл медаль 1412.5, маскны үнэ 300.0, ариутгалд 355.0, Серикбергений дансанд 354.6, насосны үнэ 280.0, худгийн засварт 478.4, нийт 4422.8 мянган төгрөг

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 60.3.1."орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ", 60.3.6-д "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд хөрөнгө зарцуулахыг хориглоно", 60.4. "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам 4.2. "ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан

021040160

гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сумын удирдлагууд болон ИТХ-ын төлөөлөгчид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд тулгуурласан бодлогоор, иргэдээс нэгдсэн зохион байгуулалттай санал авч, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, нийтийн эрх ашигт нийцээгүй хөтөлбөрт хөрөнгө зарцуулдаг зөрчил дутагдлыг таслан зогсоох.

2. ОНХС-ын хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах хөтөлбөрүүдээс удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх.

3. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 30-ны дотор Ховд аймгийн төрийн аудитын газарт³ ирүүлэхийг Ховд сумын Засаг дарга Я.Өмирхан, Санхүүгийн албаны дарга Д.Жолды, нягтлан бодогч К.Жанбота нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Ц.АЗЗАЯА

³ Монгол улс, Ховд аймаг, Цамбагараг баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545